

“Монмойд” ХК-ийн хувьцааг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, “Монмойд” ХК-ийн 2007 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.“Монмойд” ХК-ийн нийтэд санал болгож гаргасан 130019 ширхэг хувьцааг бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2.Хувь нийлүүлэгчдийн хурлаас компанийг өөрчлөн зохион байгуулах шийдвэр гаргахад оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах эрхийг хэрхэн хэрэгжүүлсэн тухай тайланг 2008 оны 8 дугаар сард багтаан Хороонд ирүүлэхийг “Монмойд” ХК /Гүйцэтгэх захирал Ж.Баяндалай/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын талаар Үндэсний татварын ерөнхий газрын харьяа Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ